

Үлгэрчилсэн загвар

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ (Илтгэх хуудас)

НЭГ.ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1.Төсвийн шууд захирагчийн үүргийн биелэлт

1.1.Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-ний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан тусгай арга хэмжээнээс бусад ... *нийт арга хэмжээ (гарц)-ний* хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 1

<i>Тусгай арга хэмжээнээс бусад хэрэгжүүлбэл зохих нийт арга хэмжээний тоо</i>	<i>Өгвөл зохих оноо</i>	<i>Өгсөн оноо /дундаж оноо/</i>
1	2	3
	0-30	

1.2.Гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон ... *тусгай арга хэмжээ (гарц)-ний* хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 2

<i>Хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний тоо</i>	<i>Өгвөл зохих оноо</i>	<i>Өгсөн оноо /дундаж оноо/</i>
1	2	3
	0-40	

1.3. *Манлайллын зорилт (орц)* бүрийн биелэлтийг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 3

<i>Манлайллын зорилт (орц)-ын тоо</i>	<i>Өгвөл зохих оноо</i>	<i>Өгсөн оноо /дундаж оноо/</i>
1	2	3
	0-30	

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт /өөрийгөө хөгжүүлэх/-ын биелэлт:

1.5. Тухайн төсвийн шууд захирагчийн төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажилласан тухай дүгнэлт:

2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийн биелэлт:

ХОЁР. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3. Гэрээний биелэлтийн үнэлгээ

3.1.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж, дор дурдсан дундаж оноогоор үнэлэв:

Хүснэгт 4

<i>Гэрээний үзүүлэлт</i>	<i>Өгвөл зохих оноо</i>	<i>Өгсөн оноо /дундаж оноо/</i>
1.Нийт арга хэмжээ (гарц)-ний биелэлт	0-30	
2.Тусгай арга хэмжээ(гарц)-ний биелэлт	0-40	
3.Манлайллын зорилт (орц)-ын биелэлт	0-30	
<i>Нийт оноо</i>	0-100	

3.2.Төсвийн ерөнхийлөн захирагч гэрээний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээгээ гэж тэмдэглэнэ.

Хүснэгт 5

"А" буюу "Маш сайн"	"В" буюу "Сайн"	"С" буюу "Хангалттай"	"D" буюу "Дутагдалтай"	"F" буюу "Хангалтгүй"
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хэрэв "А" буюу "Маш сайн", эсхүл "D" буюу "Дутагдалтай", "F" буюу "Хангалтгүй" гэсэн үнэлгээ өгсөн бол энэ тухай үндэслэлээ бичнэ:

.....
.....

4.Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1).....

2).....

.....Г.М.

5.Гэрээний биелэлтийн үнэлгээний баталгаажуулалт:

5.1.Үнэлгээ өгсөн:

Төсвийн ерөнхийлөн захирагч

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг)
(тэмдэг)

.....
(огноо)

5.2.Үнэлгээтэй танилцсан:

Төсвийн шууд захирагч

..... /...../
(албан тушаал) (гарын үсэг)
(тэмдэг)

.....
(огноо)

Үлгэрчилсэн загвар

..... (байгууллагын нэр)-ЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
(20... он)

НЭГ.НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<i>Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i>	<i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i>	<i>Тухайн нийт арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i>
1	2	3
<p>"1.0." гэсэн хөтөлбөрийн хүрээнд: Арга хэмжээ -1.1: (Арга хэмжээний нэр, шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин) Арга хэмжээ -1.2: Г.М.</p>		
<p>"2.0." гэсэн хөтөлбөрийн хүрээнд: Арга хэмжээ -2.1: (Арга хэмжээний нэр, шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин) Арга хэмжээ -2.2: Г.М.</p>		
Нийт арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО		

ХОЁР.ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<i>Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i>	<i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i>	<i>Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i>
1	2	3
<p>"3.0." гэсэн хөтөлбөрийн хүрээнд: Арга хэмжээ -3.1: (Арга хэмжээний нэр, шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин) Арга хэмжээ -3.2: Г.М.</p>		
<p>"4.0." гэсэн хөтөлбөрийн хүрээнд:</p>		

Арга хэмжээ -4.1:Г.М.		
Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО		

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

1	2	3
1. Зорилт 1: Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 1.1. 1.2..... Г.М.		
2. Зорилт 2: Байгууллагын ил тод байдлыг хангах 2.1..... Г.М.		
3. Зорилт 3: Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдал, оролцоог хангах, түүнийг зүй зохистой зарцуулах 3.1.Г.М.		
4. Зорилт 4: Байгууллагын эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах 4.1. Г.М.		
5. Зорилт 5: Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх 5.1. Г.М.		
Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО		

Тайлан бичсэн:

.....
(албан тушаал)
(тэмдэг)

Төсвийн шууд захирагч:

..... /...../
(гарын үсэг)
.....
(огноо)

Үнэлгээ өгсөн:

.....
(албан тушаал)
(тэмдэг)

Төсвийн ерөнхийлөн захирагч:

..... /...../
(гарын үсэг)
.....
(огноо)

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

"Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам (цаашид /Журам/ гэх)"-ын 2 дугаар хавсралт "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (үр дүнгийн гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-ний биелэлтийг дүгнэх)-г үнэлж дүгнэх Үлгэрчилсэн загвар (цаашид /Загвар/ гэх)"-ын дагуу төсвийн шууд захирагчийн гэрээний биелэлтийг үнэлж дүгнэхэд энэхүү аргачлалыг баримтална.

НЭГ.ТАЛУУДЫН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1.Төсвийн шууд захирагчийн үүргийн биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн шууд захирагчийн гэрээний биелэлтийг доорх байдлаар дүгнэнэ:

1.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь Загварын 1.1-ийн нийт арга хэмжээ (гарц) тус бүрийн хэрэгжилтийг Загварын хавсралт маягт (*Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан*)-аар гаргах бөгөөд арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-ийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр уг маягтын харгалзах 3 дахь баганад нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 онооны үнэлгээ өгч, дундаж оноог гаргана.

Хэрэв тухайн жилийн дундуур төсвийн ерөнхийлөн захирагчийн саналын дагуу төсвийн шууд захирагч нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэхээр тохирсон бол түүний биелэлтийг нэгэн адил үнэлнэ.

Тухайн арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрсэн бол 30, тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч гүйцэтгэлийн зарим шалгуур үзүүлэлтийг хангаагүй, үр дүнд бүрэн хүрээгүй бол 20-29, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн дуусаж, ажил хийгдэж байгаа бол энэ ажлын түвшинг харгалзан 14-19, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн бол энэ ажлын түвшинг харгалзан 5-13, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил хийгдэж эхэлсэн бол энэ ажлын түвшинг харгалзан 1-4 оноо өгч, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ямар нэг ажил хийгдээгүй бол оноо ("0" гэж тэмдэглэнэ) өгөхгүй.

Нийт арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний дундаж оноог тооцохдоо арга хэмжээ тус бүрт өгсөн онооны нийлбэрийг үнэлгээ өгсөн арга хэмжээний нийт тоонд хувааж гаргана.

Загварын 1.1-ийн "нийт арга хэмжээ (гарц)-ний" гэсний өмнөх зайд гэрээгээр хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээнээс бусад нийт арга хэмжээний тоог бичиж, Загварын Хүснэгт 1-ийг дараах байдлаар бөглөнө:

Жишээ:

Тусгай арга хэмжээнээс бусад хэрэгжүүлбэл зохих нийт арга хэмжээний тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо (дундаж оноо)
1	2	3
20	0-30	25

1.2.Төсвийн ерөнхийлөн захирагч нь Загварын 1.2-ын тусгай арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг Загварын 1.1-ийн нийт арга хэмжээний хэрэгжилтийг үнэлсэн аргачлалаар дүгнэнэ.Загварын хавсралт маягт (*Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайлан*)-ын харгалзах 3 дахь баганад тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-40 онооны үнэлгээ өгч, дундаж

оноог гаргана. Тухайн арга хэмжээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрсэн бол 40, тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч гүйцэтгэлийн зарим шалгуур үзүүлэлтийг хангаагүй, үр дүнд бүрэн хүрээгүй бол 29-39, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн дуусаж, ажил хийгдэж байгаа бол энэ ажлын түвшинг харгалзан 18-28, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн бол энэ ажлын түвшинг харгалзан 7-17, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил хийгдэж эхэлсэн бол энэ ажлын түвшинг харгалзан 1-6 оноо өгч, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ямар нэг ажил хийгдээгүй бол оноо (“0” гэж тэмдэглэнэ) өгөхгүй.

Тусгай арга хэмжээний хэрэгжилтийн дундаж оноог тооцохдоо тусгай арга хэмжээ тус бүрт өгсөн онооны нийлбэрийг үнэлгээ өгсөн тусгай арга хэмжээний нийт тоонд хувааж гаргана.

Загварын 1.2-ын “тусгай арга хэмжээ (гарц)-ний” гэсний өмнөх зайд гэрээгээр хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний нийт тоог бичиж, Загварын Хүснэгт 2-ыг дараах байдлаар бөглөнө:

Жишээ:

Хэрэгжүүлбэл зохих тусгай арга хэмжээний тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо (дундаж оноо)
1	2	3
5	0-40	35

1.3.Төсвийн ерөнхийлөн захирагч нь Загварын 1.3-ын манлайллын зорилт тус бүрийн хэрэгжилтийг Загварын хавсралт маягтын дагуу зорилт бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг гэрээнд тусгагдсан зорилт бүрийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэх үндсэн дээр уг маягтын харгалзах 3 дахь баганад зорилт бүрийн биелэлтэд 0-30 онооны үнэлгээ өгч, дундаж оноог гаргана.

Манлайллын зорилтын биелэлтийн үнэлгээний дундаж оноог тооцохдоо зорилт тус бүрт өгсөн онооны нийлбэрийг үнэлгээ өгсөн нийт зорилтын тоонд хувааж гаргана.

Загварын 1.3-ын “зорилт (орц)” гэсний өмнөх зайд гэрээгээр хэрэгжүүлбэл зохих манлайллын зорилтын нийт тоог бичиж, Загварын Хүснэгт 3-ыг дараах байдлаар бөглөнө:

Жишээ:

Манлайллын зорилт (орц)-ын тоо	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо (дундаж оноо)
1	2	3
6	0-30	20

1.4.Төсвийн шууд захирагчийн мэдлэг чадвар нь нийт болон тусгай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, манлайллын зорилтыг хангахад тусгалаа олох тул түүнийг тусгайлан дүгнэхгүй боловч биелэлтийг Загварын 1.4-ийн “биелэлт:” гэсний дараах зайд бичнэ.

1.5.Төсвийн ерөнхийлөн захирагч нь төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг мөрдөж ажиллахтай холбогдсон төсвийн шууд захирагчийн хүлээсэн үүргийн биелэлтэд дүгнэлт өгч, Загварын 1.5-ын “дүгнэлт:” гэсний дараах зайд бичнэ.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийн биелэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэхдээ:

2.1. Гэрээнд тусгагдсан төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээсэн үүргийн биелэлтийг зүйл тус бүрээр талууд хамтран хэлэлцэнэ.

2.2. Талууд төсвийн ерөнхийлөн захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж, Загварын 2-ын “биелэлт:” гэсний дараах зайд бичнэ.

2.3. Төсвийн ерөнхийлөн захирагч гэрээгээр хүлээсэн зарим үүргээ биелүүлээгүйгээс төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд сөргөөр нөлөөлсөн гэж талууд үзвэл төсвийн шууд захирагчийн тухайн хүлээсэн үүргийн биелэлтэд өгөх үнэлгээнд энэ нөхцөл байдлыг харгалзана.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

3. Гэрээний биелэлтийн үнэлгээ

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Загварын 1.1, 1.2, 1.3-т өгсөн үнэлгээг нэгтгэн Загварын Хүснэгт 4-ийг дараах байдлаар бөглөж, нийт оноог гаргана:

<i>Гэрээний үзүүлэлт</i>	<i>Өгвөл зохих оноо</i>	<i>Өгсөн оноо (дундаж жишээ) онооны</i>
1	2	3
1. Нийт арга хэмжээ (гарц)-ний хэрэгжилт	0-30	25
2. Тусгай арга хэмжээ (гарц)-ний хэрэгжилт	0-40	35
3. Манлайллын зорилт (орц)-ын биелэлт	0-30	20
Нийт оноо	0-100	80

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд өгсөн үнэлгээний нийт оноог үндэслэн гэрээний биелэлтэд журмын 6.4.1-6.4.5-д заасан үнэлгээний аль нэгийг өгнө.

3.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн шууд захирагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд өгсөн үнэлгээний нийт оноо (бидний авсан жишээгээр 80 оноо)-г үндэслэн гэрээний биелэлтэд (бидний авсан жишээгээр “В” буюу “Сайн” гэсэн) үнэлгээ өгөх бөгөөд Загварын Хүснэгт 5-ын зохих баганад (бидний авсан жишээгээр “В” баганад) үнэлгээгээ гэж тэмдэглэнэ.

3.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь гэрээний биелэлтийг дүгнэж, хэрэв “А” буюу “Маш сайн”, эсхүл “D” буюу “Дутагдалтай”, “F” буюу “Хангалтгүй” гэсэн үнэлгээний аль нэгийг өгсөн бол энэ тухай үндэслэлээ Загварын 3.2-ын холбогдох зайд бичнэ.

4. Гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Төсвийн ерөнхийлөн захирагч нь гэрээний биелэлтийн үнэлгээг үндэслэн журмын 7.1-д заасан үнэлгээний мөрөөр авах арга хэмжээ (урамшуулах, эсхүл хариуцлага хүлээлгэх)-ний тодорхой саналаа Загварын 4-т бичнэ.

5. Гэрээний биелэлтийн үнэлгээний баталгаажуулалт

Загварын 5.1-д үнэлгээ өгсөн төсвийн ерөнхийлөн захирагч, 5.2-т үнэлгээтэй танилцсан төсвийн шууд захирагч тус тусын гарын үсгийг зурж, эрх бүхий этгээд тэмдэг дарж албажуулна.